



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/43

Эмзэлтолгой

Мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд
хамруулах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Монгол Улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 31 дүгээр зүйлийн 31.4, аймгийн Засаг даргын 2022 оны А/177 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргийг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг технологийн хугацаанд буюу 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл чанартай хийж, малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийж, гүйцэтгэлийг “Мал эмнэлгийн нэгдсэн систем”-д оруулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

2. Дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн дотор тухайн малчны хотоос мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдэд хориглосугай.

3. Дээрх ажлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган, ажлын явцад байнгын хяналт тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлэн ажлын хэрэгжилт, үр дүнг сумын Засаг даргад мэдээлж, дүн мэдээг 2022 оны 11 дүгээр сарын эхний 10 хоногт багтаан аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн улсын байцаагч (С.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ



D:/2022 on/Zahiramj-2022on-docx

642201103